

**МОНГОЛ УЛСЫН ТУСГААР ТОГТНОЛЫН ТУХАЙ БҮХ АРД ТҮМНИЙ
САНАЛ ГАРГУУЛСАН 10 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР БУЮУ
“НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨР”ИЙН АРГА ХЭМЖЭЭГ ДАРХАН-УУЛ
АЙМАГТ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ ТОВЧ ТАЙЛАН**

/ 2010 оны эхний 10 сарын байдлаар/

2010.10.30

Дархан-Уул аймаг

“Нээлттэй хаалганы өдөр”-ийн арга хэмжээ нь төрийн байгууллагын мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг хангах, үйлчилгээний соёл, шуурхай байдлыг төлөвшүүлэх, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр олон талт арга хэмжээ авч ажиллах талаар Монгол улсын Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа бодлого, чиглэлийг хангахад онцгой ач холбогдолтой юм. Иймд “Нээлттэй хаалганы өдөр”-ийн арга хэмжээний ач холбогдол, үр нөлөөг дээшлүүлж, уг арга хэмжээг “Хэрэглэгчийн үнэлгээ” авах ажилтай хамтатган зохион байгуулж, энэ ажилд төрийн бус байгууллага, иргэний нийгмийн оролцоог хангахад анхааран ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Нээлттэй хаалганы өдөр зохион байгуулж байх тухай” 2007 оны 97-р зарлиг, Засгийн Газрын “Журам батлах тухай” 2007 оны 190 дүгээр тогтоол болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, оны эхэнд батлагдсан хуваарь, төлөвлөгөөний дагуу 2010 оны эхний 10 сард Дархан, Орхон, Шарын гол, Хонгор сум, аймгийн ЗДТГ, түүний хэлтсүүд, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээн дэх агентлагууд, ЦГ, ШШГА, ШША, ОБГ, УБХ, ХХҮХ, НДХ, ЭМГ, БТСГ, ХТХ, БСГ, Гаалийн алба, Статистикийн хэлтэс, Татварын. Хэлтэс, ГХБХБГ, ТАЗГ, ХХААЖДҮГ, Захирагчийн алба, БОАЖГ, СХЗХ зэрэг 25 байгууллага “Нээлттэй өдөрлөг”-өө зохион байгуулж, давхардсан тоогоор 46 төрлийн арга хэмжээнд 56874 иргэн, 273 төрийн болон ТББ, 342 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулж, 2720 иргэний санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байна. Өргөдөл, хүсэлтийн шийдвэрлэлт 99,2% -тай байна.

“Нээлттэй хаалганы өдөр”-ийн арга хэмжээний хүрээнд төрийн бодлого үйл ажиллагааг иргэдэд хүргэх, мэдээлэл өгөх, иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авах зорилгоор Бурхантын цуурай радио, МҮОНРадиоогийн Хурд агентлагийн Дархан дахь сурвалжлагч, Монголын мэдээ, Найрамдлын Дархан, Шинэ мэдээ сонин, ЛХА, Ди Би Эс, ТВ-12 телевиз зэрэг төв, орон нутгийн хэвлэл мэдээллийн 8 байгууллагаар 30 хүртэлх минутын хугацаатай 195 удаагийн мэдээлэл, сурталчилгааг зохион байгууллаа.

“Нээлттэй хаалганы өдөр”-ийн арга хэмжээг зохион байгуулахдаа салбар дундын хамтын ажиллагааг хөгжүүлэх, иргэдэд багц мэдээллийг нэг дороос хүргэх

зорилгоор нийгмийн салбар, хууль хяналтын салбар, үйлдвэрлэл, дэд бүтцийн салбар, санхүү, эдийн засгийн салбарын “Нээлттэй өдөрлөг”-ийг холбогдох хэлтэс, агентлагууд хамтран зохион байгуулсан нь үр дүнгээ өгч байна. Мөн төрийн байгууллага бүр сар бүрийн 1 өдрийг “Нээлттэй өдөр” болгон хөтөлбөр төлөвлөгөө гарган ажилласан нь төрийн байгууллагуудын идэвхи хандлагыг нэмэгдүүлж, төрийн үйлчилгээнд шинэлэг арга ажиллагааг нэвтрүүлж ажиллахад ач холбогдлоо өгч байна. “Нээлттэй хаалганы өдөр”-ийн арга хэмжээнд иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг өргөнөөр татан оролцуулж, тэдэнд мэдээлэл зөвлөгөө өгч хамтран ажилласнаар 273 төрийн болон ТББ, 342 аж ахуйн нэгж, 56874 иргэн төрийн үйлчилгээний талаарх мэдээллийг нэг цэгээс хүлээн авч чадлаа.

Аймаг, сумдын ЗДТГ-ын “Нээлттэй хаалганы өдөр”

2010 оны 1-9 сар

- Нийт 18 байгууллага “Нээлттэй утас”, “Нээлттэй микрофон”, “Саналын хайрцаг” ажиллуулж, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, зохих журмын дагуу холбогдох арга хэмжээг авч ажилласан.

- Монгол Улсын Засгийн газрын 2009 оын 143-р тогтоолд тусгасан “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийн дагуу аймгийн ЗДТГ-ын Мэдээллийн самбарыг шинэчлэн байрлуулж, www.e-darkhan.com цахим хуудсаар шаардлагатай мэдээ мэдээллийг иргэдэд нээлттэй ил тод хүргэж ажилласан. Мөн аймгийн ЗДТГ-ын байранд цахим лавлахыг байрлуулж, иргэд төрийн албан хаагчдын үйл ажиллагаанд үнэлгээ өгөх нөхцлийг бүрдүүлсэн.

- Аймаг, сумдын ЗДТГ-ын байранд буюу нийт 5 цэгт “Иргэдийг хүлээн авах өрөө”-г шинээр байгуулж, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллаж байгаагийн зэрэгцээ уг өрөөнд “Бизнес ширээ” үйлчилгээг нэвтрүүлэн иргэдэд төрийн үйлчилгээтэй холбоотой бүх төрлийн мэдээллийг хүргэн ажиллаж байна. Уг өрөөнөөс төрийн 14 байгууллагын 81, бизнес хөгжлийн үйлчилгээ үзүүлэгч 1 төрийн бус байгууллагын 3, нийт 84 үйлчилгээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хүлээн авах нөхцлийг бүрдүүллээ.

- “Иргэдээ сонсох өдөр”-ийг сумдад нийт 8 удаа зохион байгуулж, аймгийн Засаг дарга 4 сумын 24 багийн 450 гаруй иргэдтэй уулзаж, иргэдийн санал, хүсэлтийг сонслоо.

- Аймгийн УАЗөвөлгөөн дээр төрийн 25 байгууллага сонсгол мэдээлэл хийж, ажлаа тайлагнасны зэрэгцээ, уг үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр тогтмол сурталчиллаа.

- Телевизийн шууд нэвтрүүлэгт төрийн 5 байгууллага оролцож, үзэгчдийн асуултад шууд хариулж мэдээлэл зөвөлгөө өглөө.

- Аймгийн ЗДТГ, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээн дэх 9 агентлаг болон 1 төрийн бус байгууллага ард иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авч дүгнэлээ. Аймгийн ХАҮТанхим гишүүн байгууллагуудаасаа судалгаа авч үзэхэд төрийн үйлчилгээний чанар хүртээмжинд нийт оролцогчдын 9 хувь нь хангалтгүй, 75 хувь нь хангалттай үнэлгээ өгсөн байна. Бизнес эрхлэгчдийн зүгээс төрөөс татварын хөнгөлөлт эдлэх хүсэл сонирхол их байгаа нь судалгааны дүнгээс харагдаж байна.

- Орхон сумын 8-р сургууль бага ангийн 10 бүлгийн 18 эцэг эхчүүдтэй уулзалт зохион байгуулж, сургалтын нэг өдрийн үйл ажиллагаатай танилцуулж, үдийн цай, хоолны амталгаа хийлгэж, сургалтын үйл ажиллагаанд хяналт тавих бололцоог хангаж ажиллалаа.

- Хонгор сумын ЗДТГ-аас ажил үйлчилгээгээ танилцуулах өдөрлөг зохион байгуулж, 242 иргэнд үйлчилгээ үзүүлж, 1 иргэний өргөдлийг газар дээр нь шийдвэрлэсэн ба 102 иргэнд урьдчилан сэргийлэх үзлэг, 63 иргэнд шинжилгээ хийж 2 иргэнийг хяналтанд авсан байна. БЗХӨ-ийг илрүүлэх тэст 15 хүнд хийж, өвчтлөлтэй 1 иргэнийг хөнгөлөлттэй эм тариагаар үйлчилж зөвлөгөө өглөө.

- Нээлттэй хаалганы өдрийн үеэр байгууллага бүр 1 үйлчилгээг хөнгөлөлттэй үнээр үйлчлэх чиглэл өгч ажилласнаар Хонгор сумын ЗДТГ 1 иргэнд, сумын эмнэлэг 30 иргэнд хөнгөлөлттэй үнээр үйлчиллээ.

Хууль хяналтын салбарын “Нээлттэй хаалганы өдөр”

2010 оны 1-3 сар

- Аймгийн ЗДТГ-ын Хуульзүйн хэлтсээс зөвлөмж, гарын авлага, сурталчилгааны материал боловсруулж, 330 ширхгийг иргэдэд тараахын хамт холбогдох хуульзүйн зөвлөгөө өгч ажиллав.

- Орон нутгийн FM радиогоор хууль сурталчлах “Хуулийн цаг” нэвтрүүлгийг явууллаа.

- Арга хэмжээний үеэр “Шударга ёс аян”-ыг өрнүүлж, оюутан сурагчдын дунд хэлэлцүүлэг өрнүүлсний зэрэгцээ Хуульзүйн хэлтсээс “Шударга ёсны төлөө хамтдаа нэгдэцгээе!” уриаг бүх төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд илгээлээ.

- Аймгийн Цагдаагийн газраас сүүлийн үед оюутан залуус согтуугаар хэрэг зөрчилд холбогдох явдал ихэсч байгаатай холбогдуулан бүх их дээд сургуулиудад мэдэгдэл бичиж хүргүүлэн, Цагдаагийн газраас зохион байгуулж байгаа Нээлттэй хаалганы өдрийн арга хэмжээнд 800 гаруй оюутан, сурагчдыг өргөнөөр

оролцуулав. Түүнчлэн цагдаагийн албан хаагчдын бүрэн хэмжээний концерт бэлтгэж, иргэдэд сонирхуулсан нь өмнөх Нээлттэй хаалганы өдрүүдээс онцлог боллоо. Цагдаагийн газар гэмт хэрэг, зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх зөвлөмжийг боловсруулан хэвлүүлж, иргэдэд тараах арга хэмжээг зохион байгуулсан.

-УБХэлтсээс сар бүрийн 2 дахь 7 хоногийн Бямба гариг бүр бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн нь иргэдийн цаг завьг хэмнэсэн үр дүнтэй ажил боллоо.

-ОБГ-аас Орхон, Хонгор, Шарын гол, Дархан сумдын гэр хорооллын иргэдийн галын аюулгүй байдлыг хангуулах, бэлэн байдлыг газар дээр нь шалгаж, зөрчил дутагдлыг арилгуулж ажиллав.

-Гамшиг ослын бэлэн байдлын 5 цагийн сургалтыг 5 удаа зохион байгуулав.

-Гамшгаас хамгаалах эрсдэл, эмзэг байдлын түвшинг бууруулахад даатгалын үйлчилгээний ач холбогдлын талаар иргэдэд мэдээлэл өгөв.

-ОБГ-ын гамшиг осолтой тэмцэх 105 аврах бүлгийн машин техник, багаж зэвсэглэмжийн үзэсгэлэн гаргав.

-Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор “Хайрлаагүй амь” киног Орхон сумын иргэдэд сонирхуулав.

-Дархан, Орхон, Сэлэнгэ аймгийн ЕБСургуулийн ахлах ангийн сурагчдын дунд “Ирээдүйн аврагчид” үзүүлэх сургуулийг зохион байгуулав.

-Аймгийн ОБГ-аас “Хүмүүнлэг иргэн биднээс” тэмцээн зохион байгуулав.

Нийгмийн салбарын “Нээлттэй хаалганы өдөр”

2010 оны 4-6 сар

- Аймгийн БСГазраас “Од цогцолбор” -ын 11-р анги төгсөж буй 203 сурагч, 98 эцэг эх, “Оюуны-Ирээдүй цогцолбор”-ын 240 сурагч, 121 эцэг эх, 15-р сургуулийн 113 сурагч, 78 эцэг эхтэй уулзаж, ЭШШалгалт болон мэргэжил сонгох талаар зөвлөгөө өгч, боловсролын үйл ажиллагааны талаар танилцуулга мэдээлэл өгсөн.

- Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр Элсэлтийн Ерөнхий шалгалтын талаар мэдээлэл зөвлөгөө өгч, хэвлэлийн бага хурал зохион байгуулав. Орон нутгийн ЛХА, DBS, ТУ-12 телевиз болон БСГ-ын “Боловсрол” сувгаар 06-р сарын 5-9-ны өдрүүдэд хуваарийн дагуу ЭШШ-ын талаар зөвлөгөө мэдээллийг нийтэд хүргэсэн.

- Элсэлтийн ерөнхий шалгалтын үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн байгууллага болон иргэдэд нээлттэй хүргэх зорилгоор ЭШШ-ын нээлтийн үйл ажиллагаа болон шалгалт бүрийн тест сэдэв задлах, битүүмжлэх явцыг

телевизээр нэвтрүүлж, шалгалт явагдаж буй танхим бүрт камер ажиллуулж, ЛХА телевизээр нийтэд цацсан.

- Их дээд сургууль коллежид шинээр элсэн орогсдод хуваарь олголт хийх, иргэд элсэгчдийн санал, гомдлыг нээлттэй шийдвэрлэж ажиллалаа.

- Загвар цэцэрлэгийн үйл ажиллагааг жигдрүүлж, иргэд, эцэг эхчүүдэд мэдээлэл өгч, загвар цэцэрлэгийн хүний нөөц болох багш нарт 7-р сарын 1-ээс 7-р сарын 05-ны хооронд сургалт зохион байгууллаа.

- ЕБС-ийн сургууль, цэцэрлэгүүдийн гадна талбайг тохижуулах зорилгоор ЕБС, цэцэрлэг соёлын байгууллагад 560 гаруй сая төгрөгийн их болон урсгал засварын ажлыг хийж гүйцэтгэлээ.

- Монголын хүүхдийн байгууллагын 85 жилийн ойн хүрээнд “Түүхэнд мөнхөрсөн 85 жил” уран бүтээлийн үзэсгэлэн гаргалаа.

- Хөгжлийн түлхүүр-хүүхэд бидний гарт” хүүхдийн 5-р чуулганыг зохион байгуулав.

- Эрүүл мэндийн газар: “Хотжилт-Эрүүл мэндийн асуудлууд” сэдэвт өдөрлөг зохион байгуулж, 2500 иргэн хамрагдав.

- Хот дотор 2,5 км-ийн явган аялалд 2500 иргэнийг хамруулав.

- Залуучууд театрт болсон өдөрлөгийн үеэр 1283 иргэнд үзлэг, оношилгоо хийж, эрүүл мэндийн чиглэлээр 85 төрлийн 3211 ширхэг гарын авлага, сурталчилгааны материал тарааж, үйлчилгээ үзүүлэв.

- “Эм импекс” компани “Эмийн зохистой хэрэглээ”-ний талаар сургалт, сурталчилгаа хийж, 320 гаруй тараах материал тараав.

- 400 гаруй ахмад оролцсон “Хээрийн цай амттай” явган аялал зохион байгуулав.

- Дархан сумын 1-3 багийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй хамтран “Эрүүл мэнд-Хөдөлгөөн” өдөрлөг зохион байгуулж, 128 ХБИргэнийг хамруулж, 165,0 мянган төгрөг зарцуулсан.

- Биеийн тамир спортын газраас “Олимпизм Дархан”-д аяныг зохион байгуулав.

- “Хүн бүр өдөрт 10000 алхацгаая” уриаг хэрэгжүүлэн өдөр бүр “Миний Монгол” цэцэрлэгт хүрээлэнд тогтмол хөдөлгөөнөөр хичээллэдэг ахмадуудыг бүртгэж, МУОХорооны дурсгалын зүйлээр шагналаа.

- “Олимпизм-Дархан 50 жил” бүх нийтийн гүйлтийн арга хэмжээг Хүчний байгууллагуудын дунд зохион байгуулж, нийт 4 байгууллагын 300 гаруй тамирчид оролцлоо.

- “Спорт-Олимпизм” сэдэвт шүлгийн уралдааныг аймгийн Ахмадын зөвлөлтэй хамтран зохион байгуулж, 4-р багийн иргэн Ичинхорлоо “Илүү, Илүү шүү” шүлгээрээ 1-р байранд шалгарлаа.

-“Завгүй хүмүүс-Спортын талбарт” бизнесийн байгууллагуудын дунд спортын 5 төрлөөр тэмцээн зохион байгуулж, 11 байгууллагын 130 тамирчин оролцлоо.

- “Олимпизм-Авто тээвэрчид” авто тээврийн байгууллагын 85 жилийн ойн нэрэмжит тэмцээнийг сплотын 5 төрлөөр зохион байгуулж 12 байгууллагын 120 гаруй тамирчид оролцлоо.

- Миний Монгол цэцэрлэгт хүрээлэнд Софт теннис, талбайн теннисний 2 ш стандартын шаардлага хангасан 16,000,000 төгрөгний өртөг бүхий талбайг ашиглалтанд орууллаа. “Дарханы цом-2010” софт теннисний олон хотын тэмцээнийг зохион байгуулж, 10 байгууллагын 100 орчим багш дасгалжуулагч, тамирчид оролцлоо.

- Нийгмийн Даатгалын Хэлтсээс Монгол Улсын Нийгмийн даатгалын болон иргэний эрүүл мэндийн даатгалын хууль, тогтоомжуудыг олон нийтэд сурталчлан таниулах, мэдээлэх, иргэдийг даатгалд өргөнөөр хамруулах, тэтгэвэр тэтгэмж, төлбөр тогтоон олгох, ЭМД-ын сангаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардал, даатгалын хөнгөлөлттэй эмээр үйлчилдэг эмийн сангуудын үйлчилгээг сурталчилж, Зөвөлгөө мэдээлэл өгөх цэгийг сумдад ажиллуулсан.

- Нийгмийн даатгалын үйл ажиллагааг сурталчилсан 6 танилцуулга самбар ажиллуулж, иргэдэд 3000 гаруй гарын авлага, материал тарааж, сурталчилгааны киног дэлгэцээр үзүүлсэн.

- Улсын болон хувийн эмнэлэг, эмийн сан зэрэг 10 гаруй байгууллага үзлэг үйлчилгээ үзүүлж, хөнгөлөлттэй олгодог эмийн үзэсгэлэн гаргасны зэрэгцээ 595 иргэд даатгуулагчид үнэ төлбөргүй үзлэг, оношилгоо, витаминжуулах үйлчилгээ үзүүллээ.

Санхүү, эдийн засгийн салбарын “Нээлттэй хаалганы өдөр”

2010 оны 6-8 сар

- 2010 оны Хүн ам, орон сууцны тооллогын талаарх сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулав.

- Аймгийн Гаалийн албанаас “Харилцагчийн уулзалт”-ыг зохион байгуулж, гаалийн байгууллагын үйлчилгээний талаар тэдний санал сэтгэгдлийг сонсч харилцан ярилцлаа.

- Аймгийн Татварын хэлтсээс зөвлөмж, гарын авлага, материалыг тараах, тайлангийн маягтаар хангах төрөл бүрийн сургалт явуулах ажлуудыг зохион байгуулсан.

- НӨАТ-ын тайланг 100 хувь цахимаар авахтай холбогдуулан, НӨАТ-ын тайлан, падаан шивэх аргачлалын талаар, зөвлөгөө өгөх зорилгоор сар бүрийн 10-нд Харилцагчийн уулзалт, ярилцлага зохион байгуулж хэвшүүлэв.

- Аймгийн Татварын хэлтсийн байран дахь “Татвар төлөгчдийн өрөө”-гөөр 300 гаруй татвар төлөгчид үйлчлүүллээ.

- Татвар төлөгчдийн өдрүүдийн хүрээнд Татвар төлөгчдийн зөвөлгөөн зохион байгуулсан.

- ЕБС-ийн сурагчдад зориулан “Татвар бидний амьдралд” сэдвээр хичээлийн програм бэлтгэж, Дархан, Хонгор сумдын сурагчдад сургалт явуулсан.

- Арилжааны банкуудын үйлчилгээний зааланд сурталчилгааны самбар, нийтийн тээврийн хэрэгсэлд сурталчилгааны материал тус тус байрлуулсан.

- Их дээд сургуулиудын оюутнуудын дунд татварын эрхзүйн асуудлаар “АХА” тэмцээн зохион байгуулсан.

- Залуучууд театрын зааланд татвар төлөгч 32 аж ахуйн нэгж байгууллага оролцсон үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан.

Үйлдвэрлэл, дэд бүтэц, байгаль орчны салбарын “Нээлттэй хаалганы өдөр” 2010 оны 9-12 сар

- Дархан Дулааны Цахилгаан станц ТӨХК нь нээлттэй өдөрлөгөө салбарын хэмжээнд зохион байгуулж, иргэдэд үйл ажиллагаагаа сурталчиллаа. Компаны танилцуулга, эрчим хүчний болон бүтээмжийн сэтгүүл, сургалтын лабораториудын танилцуулгыг иргэдэд танилцуулж, холбогдох гарын авлага, боршурыг тараалаа.

- ДСЦТС ХК нь нээлттэй өдөрлөгөө 4 суманд зохион байгуулж, байгууллага сурталчлах бүтээлч ажил өрнүүлэх, эрчим хүчний хууль дүрмийг танилцуулах, байгууллагын төлбөрт үйлчилгээг танилцуулах, 0,4кВ-ын дуудлага болон тоолуур баталгаажуулалтыг үнэ төлбөргүй үйлчлэх, хэрэглэсэн эрчим хүчний төлбөрийг барагдуулах, шинээр нэвтрүүлж байгаа техник, технологийг танилцуулах, сурталчлах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Мөн Дархан сумын 5-р багийн хэсэгт хүчдэлгүй байгаа 20 айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах ажлыг хийж гүйцэтгэлээ. Нийт 30 тоолуурыг төлбөргүй баталгаажуулж, 31 зөрчлийг илрүүлж, холбогдох арга хэмжээг авч ажиллалаа. “Нээлттэй хаалганы өдөр”-өөр нийт 120 дуудлага хүлээн авч, үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүллээ.

- Аймгийн НААҮГазраас нохой устгалын ажлыг 10 дугаар сараас эхлүүлж, нийт 200 гаруй эзэнгүй нохой устгалаа.

- Аймгийн БОАЖГазар, ХААИСургуультай хамтран Хараа голын эрэг орчмыг цэвэрлэх ажлыг хийж гүйцэтгэлээ.

- Дархан хот байгуулагдсаны 49 жилийн ойг тохиолдуулан аймгийн ТАЗГазраас “Азтай зорчигч”-ийг шалгаруулж, үнэгүй зорчих эрхээр шагналаа.

Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн харьяа хэлтэс агентлагууд 2010 оны 12 дугаар сарыг дуустал Нээлттэй өдөрлөгөө хөтөлбөрийн дагуу үргэлжлүүлэн зохион байгуулна.

Монгол улсын тусгаар тогтнолын тухай бүх ард түмний санал гаргуулсан **10 дугаар сарын 20**-ны өдрийг “**Нээлттэй хаалганы өдөр**” болгон жил бүр улс даяар зохион байгуулахаар тогтоосны дагуу Дархан-Уул аймаг уг арга хэмжээг Дархан хот байгуулагдсан өдрийн арга хэмжээтэй хамтатган зохион байгуулж, аймгийн Засаг дарга ард иргэддээ хийсэн ажлаа тайлагнаж, тэдний санал хүсэлтийг нь хүлээн авч, холбогдох арга хэмжээг шуурхай авч ажиллалаа.

Энэ үеэр Цагдаагийн хяналтын иж бүрэн систем, орон сууцны дээврийн засварын ажил, зам засвар, гэрэлтүүлгийн ажил, төрийн албан хаагчийн орон сууц барих ажил зэрэг 2010 онд хийсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг хүлээн авах ёслолын ажиллагааг иргэдтэйгээ хамтран зохион байгууллаа. Аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлыг “Дархан 50” цогцолбор дээр зохион байгуулж, уг цогцолборын бүтээн байгуулалтын явцтай танилцаж, зарим асуудлыг газар дээр нь үзэж шийдвэрлэлээ.

Аймгийн Засаг дарга жил бүрийн 10 дугаар сард сумдын иргэд хөдөлмөрчидтэй уулзаж, ирэх жилийнхээ ажлын төлөвлөгөө, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх зорилтыг тодорхойлоход иргэдийн саналыг тусгадаг уламжлал ёсоороо Дархан, Орхон, Хонгор, Шарын гол сумдын нийт 450 гаруй иргэдтэй баг дээр нь очиж уулзаж, санал, хүсэлтийг нь сонссоны зэрэгцээ иргэдийн санал, хүсэлтийн мөрөөр авч хэрэгжүүлэх 25 заалт бүхий арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

ТАНИЛЦСАН: ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ЗДТГ-ЫН ДАРГА

Т. ГАНБОЛД

ХЯНАСАН: ТӨРИЙН ЗАХИРГАА,
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б. АРЪЯА

ТАЙЛАН НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:
ТЗУХ-ИЙН ХШҮ-НИЙ ТАСГИЙН
МЭРГЭЖИЛТЭН

О. БУЯНАА

Монгол улсын сайд, ЗГХЭГ-ын дарга

Ч. Хүрэлбаатар.танаа

Монгол Улсын Тусгаар тогтнолын тухай бүх ард түмний санал гаргуулсан 10 дугаар сарын 20-ны өдөр буюу “Нээлттэй хаалганы өдөр”-ийн арга хэмжээг Дархан-Уул аймагт зохион байгуулсан тухай товч тайланг хавсралтаар хүргүүлэв.

Хавсаргасан материал : хуудас

Дарга

Т. Ганболд

1. Нээлттэй хаалганы өдрийн үеэр бизнес эрхлэгчдийн зүгээс зарим нэг тухайлбал Гаалийн албаны ажилтнуудын ажлын цагийг уртасгах, хагас бүтэн сайн өдрүүдэд ажиллуулах, банкны хуулга факсаар авах гэж цаг их алддаг тул банкуудтай гэрээ байгуулж ажиллах зэрэг санал гарсныг Гаалийн Ерөнхий газар, Хаан, Голомт зэрэг банкуудтай хамтран шийдвэрлэсэн. Аймгийн Гаалийн албаныхан хагас сайн өдөр ажиллаж байна.

2. Гэмтлийн зэрэг тогтоох үзлэгийн төлбөрөөс чөлөөлүүлэх тухай 2 иргэний хүсэлтийг аймгийн ШША –наас шийдвэрлэж, төлбөрөөс 100 % чөлөөлсөн.
3. Орон нутгийн шилжүүлгээ өөрийн биеэр очиж хийлгэж чадахгүй байгаа тул албаны шугамаар шийдвэрлэж өгөхийг хүссэн иргэдийн хүсэлтийн дагуу 11 иргэний асуудлыг шийдвэрлэсэн.
4. Бичиг баримт авахад бүртгэлийн үнэ, хураамжаас хөнгөлж өгөхийг хүссэн иргэдийн хүсэлтийг шийдвэрлэх боломжгүй тухай хариу өгсөн.
5. Аймгийн УБХ нь төрийн бус байгууллагуудыг орон нутагт бүртгэдэг болох тухай хүсэлтийг УБГазарт хүргүүлсэн.
6. Аймгийн БСГ нь ЭЕШ-ын талаар 34 иргэний санал, гомдлыг бүрэн шийдвэрлэсэн бөгөөд энэ жил 680 суралцагч их дээд сургуульд элсэн орсон. Боловсрол соёлын байгууллагад ажилд орохыг хүссэн 23 иргэний хүсэлтийг хүлээн авч, 7 иргэнийг ажлын байраар хангасан.
7. Аймгийн ХТХэлтэс нь эмчилгээний зардал хүссэн 1 иргэнд 900,0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж, гэр хүссэн 1 иргэнд орон гэр олгох ажлыг Монголын Төмөр замын удирдах газар, ДЗОУБ-тай тус тус хамтран хэрэгжүүллээ
8. Дархан-Уул аймгийн Хөл бөмбөгийн 3 багийн тамирчдын хүсэлтийн дагуу тэдний бэлтгэл сургуулилтаа хангах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор аймгийн Спортын ордонд байрлуулсан.
9. Иргэний гомдлын дагуу Орхон суман дахь Мөнхийн тун эмийн сангийн зөрчлийг барагдуулж, даатгалаас санхүүждэг хөнгөлөлттэй эмийн хүртээмжийг нэмэгдүүлсэн

Аймгийн БСГазар, ХХҮХэлтэс, НДХэлтэс, БТСГазар, ХТХэлтэс, Статистикийн хэлтэс, Гаалийн хороо зэрэг байгууллагууд Нээлттэй өдөрлөгөө зохион байгуулсан боловч хөтөлбөр, төлөвлөгөөгөө танилцуулаагүй, зохиогдож буй арга хэмжээнүүдэд хэлтэс агентлагийн дарга нарыг оролцуулаагүй, мэдээлэл сурталчилгаа муу хийсэн нь арга хэмжээнүүдэд явцын хяналт тавихад хүндрэлтэй байлаа.

Аймгийн Засаг даргын 2010 оны 3 дугаар албан даалгаврын дагуу төрийн байгууллага бүр сар бүрийн нэг өдрийг Нээлттэй өдөр болгон тодорхой ажил зохион байгуулж мэдээг тухай бүр ирүүлж байх үүргээ аймгийн Татварын хэлтэс, ЭМГ зэрэг байгууллагууд сайтар биелүүлж байгааг энд хэлэх нь зүйтэй.

Цаашид байгууллага бүр дээрх албан даалгаврын хэрэгжилтийг хангаж, сар бүр тодорхой арга хэмжээ зохион байгуулж, тайлан мэдээг загвар хүснэгтийн дагуу

/хавсралт 1/ гаргаж, дараа сарын 3-ны өдрийн дотор ирүүлж байхыг мэдэгдэж байна.

“Нээлттэй хаалганы өдөр”-ийн арга хэмжээг Хэрэглэгчийн үнэлгээ авах ажилтай хамтатган зохион байгуулж, энэ ажилд төрийн бус байгууллага, иргэний нийгмийн оролцоог ханган ажиллахыг зөвлөж байна.